



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ГОВЬ-УГТААЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 28 өдөр

Дугаар 8/37

Хажуу шинэ-Ус

Хязгаарлалтын дэглэмийг
хорио цээрийн дэглэмд шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж , түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1, 32 дугаар зүйлийн 32.1.1, Малын эрүүл мэндийн тухай хуулийн 17 дугаар зүйл 17.2, 17.2.1, Улсын мал эмнэлгийн ариун цэврийн төв лабораторийн 2023 оны 04 дүгээр сарын 28-ний өдрийн шинжилгээний 23-3252 дүнг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тус сумын Морьт багийн “Булгийн улаан өндрийн гэзэг” нутагт бог малын мялзан өвчний голомт үүссэн тул 2023 оны 04 сарын 28-ны өдрөөс эхлэн 21 хоногийн хугацаатай хорио цээрийн дэглэмийг тогтоосугай.

2.Хорио цээрийн бүсэд хийгдэх халдвартгүйжүүлэлт, дархлаажуулалтыг зохих заавар журмын дагуу чанартай хийж гүйцэтгэхийг Мал эмнэлгийн тасаг, Угтаал чандмань мал эмнэлэг үйлчилгээний нэгжид үүрэг болгосугай.

3.Хүн малын шилжилт хөдөлгөөн, хяналтын постыг 24 цагаар ажиллуулан, хяналт тавин ажиллахыг Мал эмнэлгийн тасгийн Улсын байцаагч (А.Бямбадорж), хэсгийн цагдаа (Б.Наранбаатар) нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА  Т.АРИУНАА